

UCS 1403C:2020

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ



Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд
байршуулах хогны саванд тавигдах шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Нийтийн эзэмшлийн гудамж зам
талбайд байршуулах хогны саванд
тавигдах шаардлага



ГАРЧИГ

1. ЗОРИЛГО.....	3
2. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
3. НОРМАТИВ ЭШЛЭЛ	3
4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ	3
5. ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙД БАЙРШУУЛСАН ХОГНЫ САВЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
6. ХОГНЫ САВАНД ТАВИХ ШААРДЛАГА.....	5
7. ТӨРӨЛ АНГИЛАЛ	6
8. ХОГНЫ САВЫГ БАЙРЛУУЛАХ.....	7
9. ХОГНЫ САВЫГ СУУРИЛУУЛАХ	7
10. ХОГНЫ САВ АШИГЛАЛТ.....	8
11. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	8
12. ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ	8
13. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХОГНЫ САВ ЗАГВАР	9
14. ХОГНЫ САВНЫ ӨНГӨ	10
15. ХОГ ХАЯГДЛЫГ ЯЛГАН АНГИЛАХ ТЭМДЭГ	10
16 ХОГНЫ САВ МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА	11
17 АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	12

ХОТЫН СТАНДАРТ

ХОГНЫ САВ



- Ерөнхий шаардлага
- Төрөл ангилал
- Загвар, дизайны удирдамж
- Байрлуулах удирдамж
- Суурилуулах техник
- Ашиглалт

1. ЗОРИЛГО

1.1 Энэхүү баримт бичгийн зорилго нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хогны сав байрлуулах үйл ажиллагаанд нэгдсэн арга зүйн удирдамж өгч, хотын оршин суугчдын эрүүл ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, дахин боловсруулах хог хаягдлыг үр дүнтэй ялгах нөхцөл боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Энэхүү баримт бичгийг нийтийн эзэмшлийн зориулалт бүхий хогны савны үйлдвэрлэл, гудамж, зам, талбай, цэцэрлэгт хүрээлэнд байрлуулах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа захиалагч, барилгын зураг төсөл боловсруулж байгаа зураг төсөл зохиогч, барилгын ажлын гүйцэтгэгч, иргэн, аж ахуйн нэгж, энэ чиглэлээр хяналт тавих эрх бүхий байгууллага хэрэглэнэ.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, барилгын норм ба дүрэм баримт бичгүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1 Барилгын орчны тохижилт, БНБД 3.01.06-90;
- 3.2 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт, БД 32-101-17 ;
- 3.3 Явган хүний зам талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага, MNS 6808:2019;
- 3.4 Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30.01.04;

4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 **Хогны сав** - гэж хог хаягдлыг түр байршуулах, хадгалах савыг;
- 4.2 **Дахивар** - гэж дахин боловсруулах хог хаягдал буюу шил, лааз, хуванцар, төмөр гэх мэт хоёрдогч түүхий эдийг;
- 4.3 **Хогны савны тэмдэг** - гэж хогны савны зориулалт, дахиврын төрөл, ангиллыг дүрс, өнгөөр ялгасан тэмдгийг;

5. ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙД БАЙРШУУЛСАН ХОГНЫ САВЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1 Гудамж зам талбайд байршуулсан хогны савыг энэхүү баримт бичигт тавигдаж байгаа материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг гудамж зам талбайн хогны сав хүлээн авах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 1.)-ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.


Хүснэгт 1. Хогны савыг хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Байрлал - Хогны савыг харагдахуйц зөв байрлалд, зөв харуулж байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Суурилуулалт - Хогны савыг стандартын дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хогны саванд дахивар, хог хаягдлын тэмдгийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Хогны савны багтаамж хүрэлцээтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Хогны сав хэмжээний стандартад нийцэж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Хогны сав стандартад нийцсэн материалаар хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Хогны савны металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Хогны сав нь дахивар, цаас, шил, хуванцар, төмөр болон бусад хогийг ялган хаях шаардлагыг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Тамхи татах цэгт зориулсан дахивар хогны савны стандарт шаардлагыг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Тамхи татах цэгт зориулалтын хогны савыг байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Тухайн хэсэгт ашиглагдаж байгаа дахивар хогны савны нэгэн төрөл, жигд байдал хангагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Хотын нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн хогны сав нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

6. ХОГНЫ САВАНД ТАВИХ ШААРДЛАГА

- 6.1 Нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт хүрээлэн, зам талбайд байрлуулсан хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогны сав нь нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бөгөөд хотын, байгаль орчин, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулж ашиглах үйл ажиллагааг дэмжих бодлогын үндэс юм.
- 6.2 Төлөвлөлтийн дагуу барьж байгуулсан, мөн нийгмийн шаардлагаар бий болж байгаа олон нийтийн орон зай, амралт чөлөөт цаг өнгөрүүлэх газар, үйлчилгээний төвүүдтэй уялдаатайгаар хогны савыг байрлуулна.
- 6.3 Хогны сав нь бат бөх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, зэврэлтээс хамгаалагдсан байх.
- 6.4 Хогны савны хог цуглуулах хэсгүүд нь цаасан дахивар болон бусад хог хаях зориулалтыг заасан стандарт мэдээлэх тэмдэгтэй байх.
- 6.5 Хогны сав нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн байх.
- 6.6 Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн тагтай байна.
- 6.7 Түгээмэл хэрэглэгддэг угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байна.
- 6.8 Хогны савны металл хийцийн эд ангийг зэврэлтээс хамгаалж стандарт шаардлага хангасан будгаар, энэхүү стандартад заасан өнгөөр, технологийн дагуу будсан байна.
- 6.9 Нийтийн эзэмшлийн хогны савны стандарт хэмжээг Зураг 1. болон Хүснэгт 2. -т тус тус үзүүлэв.



Зураг 1. Гудамж зам талбайн хогны сав

Хүснэгт 2. Хогны савны хэмжээ

Таних тэмдэг	Хэмжээний нэр	Хэмжээ /мм/
H	Өндөр	1050
B	Өргөн	450 (±20)
L	Урт	400 – 500

7. ТӨРӨЛ АНГИЛАЛ

7.1 Нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт хүрээлэн, зам, талбайд байрлуулах хогны савыг дан савтай, хос савтай, гурван савтай, зөөврийн болон тамхи татах цэгт зориулсан гэж ангилна. Жишээ зураг:



Зураг 2. Дан хогны сав



Зураг 3. Хосолсон хогны сав



Зураг 4. Олон төрлөөр ангилах хогны сав



Зураг 5. Тамхи татах цэгийн хогны сав

360литр

240литр

180литр

140литр



1080x580x875



1060x575x730



1060x480x730



1060x480x550


Зураг 6. Түр байрлуулах, зөөврийн хогны сав

8. ХОГНЫ САВЫГ БАЙРЛУУЛАХ

- 8.1 Хогны сав нь харагдахуйц, хүртээмжтэй байх нь чухал бөгөөд хөдөлгөөний эрчим төвлөрч байгаа газруудад байрлуулж оршин суугчдад хог хаягдлаа ялган хаях боломж олгож байх.
- 8.2 Хогны савыг байрлуулах тохиромжтой байрлал нь сандал суудлаас 3-аас 14 метр зайд байрлуулах нь тохиромжтой гэж үздэг боловч тодорхой заах боломжгүй учир орох хаалга, гарц, бие засах газар, явган хүний зам, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол болон бусад ачаалал ихтэй газрын ойролцоо байрлуулна.
- 8.3 Хогны савнаас хог хаягдлыг зөөж тээвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулахад хялбар байршилд байх.

9. ХОГНЫ САВЫГ СУУРИЛУУЛАХ

- 9.1 Хогны савыг байрлуулсан газарт хөдөлгөөнгүй бэхэлж суурилуулах бөгөөд зөвхөн тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлнэ.
- 9.2 Хогны савыг суурилуулах суурийн хэсэглэлийг Зураг 8-д үзүүлэв.



Зураг 8. Хогны сав суурилуулах



Зураг 9. Хэсэглэл-1

10. ХОГНЫ САВ АШИГЛАЛТ

- 10.1 Хотын оршин суугчид нэгдсэн төлөвлөлт, зураг төсөл, менежментээр дамжуулан хогны савыг зориулалтын дагуу, соёлтой ашиглах.
- 10.2 Хогны савыг зүй бусаар ашиглах, эвдэх, гэмтээх, сүйтгэх, устгах гэх мэт зүй зохисгүйгээр ашиглаж бүрэн бүтэн байдлыг алдагдуулахыг хориглоно.
- 10.3 Хогны савыг өмчлөгч, ашиглагч байгууллагуудын зөвшөөрөлгүй зөөж шилжүүлэхийг хориглоно.

11. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 11.1 Нийтийн эзэмшлийн хогны сав бүртгэл хөтлөх, цэвэрлэгээ, засвар үйлчилгээг төлөвлөх хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүртгэл хяналтын систем” болон “Хог хаягдлын менежментийн систем” нэвтрүүлж цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд нэр төрөл тус бүрээр бүртгэх, хянах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, засварлах хуваарь гаргаж хөтөлбөр боловсруулж ажиллана.



Зураг 9. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүртгэл хяналтын систем

12. ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- 8.1 Хогны савны бохирдол, элэгдэл, эвдрэлээс шалтгаалан иргэдэд осол гэмтэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг үнэлж байнгын хяналт, үнэлгээ хийж цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.

Хүснэгт 3. Хогны сав ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх чиглэл

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Бохирдсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хогны савны гадаргын бүрэн бүтэн байдал хангагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан, гээгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Зэврэлт үүссэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

13. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХОГНЫ САВНЫ ЗАГВАР

13.1 Хогны суурин систем №UCS PPR01



13.2 Хогны зөөврийн сав №UCS PPR02



13.3 Тамхины цэгийн хогны сав №UCS PPR03



14. ХОГНЫ САВНЫ ӨНГӨ

№	Нэр, тэмдэглэгээ	Өнгө	Өнгөний код
1	Ногоон RAL 6016 /#00694c/		C - 84, M - 11, Y - 98, K - 1
2	Саарал RAL 7035 /#c5c7c4/		C - 0, M - 0, Y - 0, K - 30



















Зураг 10. Хогны савны өнгө

15. ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАХ ТЭМДЭГ

15.1 Хог хаягдлыг ангилан ялгах таних тэмдгийг зөв ашиглах нь аливаа хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй.

15.2 Зааварчилгааны тэмдгийг үндсэн болон нэмэлт тэмдэг гэж ангилна. Дараах хүснэгтэд /Хүснэгт 4./ дахивар хог ялгах таних тэмдгийн хэмжээг үзүүлэв.

Хүснэгт 4. Дахивар хог ангилан ялгах тэмдэг







Үндсэн тэмдэг 340мм x 240мм	Туслах тэмдэг /Том/ 570мм x 200мм	Туслах тэмдэг /Жижиг/ 370мм x 120мм
		 C86 M21 Y81 K6
		 C0 M60 Y100 K0
		 C88 M52 Y0 K0
		 C75 M68 Y67 K90
		 C20 M100 Y100 K12
		 C0 M0 Y0 K100

Тайлбар: Энэхүү баримт бичигт дурдсан тэмдгийн төрлүүд нь олон улсын жишигт нийцсэн, олон удаагийн туршилт судалгаагаар батлагдсан болно.

16. ХОГНЫ САВ МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

- 16.1 Монгол орны цаг уурын эрс тэрс нөхцөл байдалд байрлах хогны сав нь галд тэсвэртэй, зэвэрдэггүй ган буюу металл материалтай байна.
- 16.2 Хогны савны гадаргуугийн бүрэх металл хуйлмал хавтан нь 2мм буюу түүнээс зузаан байна.
- 16.3 Үндсэн рам, хийцийн материалын төрлийг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5. Материалын төрөл, үзүүлэлт

№	Материалын нэр	Төрөл, марк	Зузааны хэмжээ	Огтлолын хэмжээ, мм	Ханын зузааны хэмжээ, мм	Хүндийн хэмжээ, м/кг
1	Дөрвөлжин металл хийц (квадрат)			A=20x20 A=25x25 A=30x30 A=40x40	S=1.5-2.0	1.07-1.39
2	Тэгш өнцөгт металл хийц			A=40x25 A=30x20	S=1.5-2.5	0.64-1.5
3	Металл хавтан				S=2-4	0.8-2

17. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Барилгын орчны тохижилт, БНБД 3.01.06-90;
- Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт, БД 32-101-17 ;
- Явган хүний зам талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага, MNS 6808:2019;
- Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30.01.04;
- Better Practice Guide for Public Place Recycling, <https://www.epa.nsw.gov.au>
- Public place recycling - Sustainability Victoria, <https://www.sustainability.vic.gov.au>
- Waste Signage Guidelines, <https://www.sustainability.vic.gov.au>

Ерөнхий зөвлөх	С.Төмөрдулам <i>Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга</i>
Редактор	О.Оджаргал <i>Орлогч дарга</i> Б.Од-Эрдэнэ <i>Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга</i>
Боловсруулсан	Д.Баасанжав <i>Мэргэжилтэн</i>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар